



ОНЦГОЙ БАЙДЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ДААЛГАВАР

2026 оны 01 сарын 30 өдөр

Дугаар 02

Улаанбаатар хот

Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай

Улсын Онцгой комиссын 2026 оны “Ой, хээрийн гал түймрээс урьдчилан
сэргийлэх, тэмцэх зарим арга хэмжээний тухай” 01 дүгээр албан даалгаврын
хэрэгжилтийг хангуулах, ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажлыг эрчимжүүлэх
зорилгоор ДААЛГАХ нь:

Нэг. Захиргаа, эрх зүй, хүний нөөцийн газрын дарга,
хурандаа Б.Үнэнбаатарт

1.1.Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх алба хаагчдыг эрүүл
мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон хачигт халдвараас урьдчилан сэргийлэх,
дархлаажуулах тарилгад хамруулах, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулахыг;

1.2.Ой, хээрийн гал түймрийн голомтод удаан хугацаагаар (10 хоногоос дээш)
үүрэг гүйцэтгэж буй алба хаагчдад эрүүл мэнд, сэтгэл зүйн тусламж, үйлчилгээ
үзүүлэх зорилгоор эмнэлгийн хөдөлгөөнт баг томилон ажиллуулах, тарилга,
эмнэлгийн хэрэгсэл, ороох боох материалын нөөц бүрдүүлэхийг;

Хоёр. Ажиллагааны удирдлагын газрын дарга,
хурандаа А.Дашнямд

2.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн гамшгаас хамгаалах төлөвлөгөөний
хэрэгжилтэд хяналт тавих, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, сайн дурын
хэсгийн хүн, хүч техник хэрэгслийн ой, хээрийн гал түймэртэй тэмцэх бэлтгэл бэлэн
байдлыг хангуулахыг;

2.2.Ой, хээрийн гал түймэрт өртсөн мал амьтныг устгах, ариутгал
халдваргүйжүүлэлт хийх, нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдэгчдэд эмнэлгийн тусламж
үйлчилгээ үзүүлэх зэрэг ажиллагаанд гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангийг
татан оролцуулах, бэлтгэл бэлэн байдал хангахыг;

2.3.Ой, хээрийн гал түймэр гарсан газар орны цаг агаарын нарийвчилсан
мэдээг тухай бүр гаргаж холбогдох бүтцийн нэгжид хүргэхийг;

Гурав. Гал түймэртэй тэмцэх газрын дарга,
хурандаа Ц.Нямбаярт

3.1.Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх ажиллагааг мэргэжлийн удирдлагаар
хангах, нөхцөл байдлыг үнэлж, нэмэлтээр хүн хүч ажиллуулах арга хэмжээг зохион
байгуулахыг;

1426020005

3.2.Хил орчмын болон алслагдсан бүс нутагт гарсан ой, хээрийн гал түймрийн голомтод хүн хүчийг шуурхай хүргэх Төрийн цэргийн болон Онцгой байдлын байгууллагын нисдэг тэрийг тусгай үүргийн нислэг үйлдүүлэх талаар саналыг танилцуулж, шийдвэрлүүлэхийг;

3.3.Ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй бүс нутагт үйл ажиллагаа эрхэлдэг айл өрх, амралтын газар, жуулчны бааз, иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламж, үйл ажиллагаанд гал түймрийн улсын хяналт шалгалтыг батлагдсан удирдамжийн дагуу зохион байгуулж, зөрчлийг арилгуулах ажиллагаанд хяналт тавихыг;

Дөрөв. Улсын нөөцийн газрын дарга,
хурандаа Ч.Цогбаярт

4.1.Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн, олон хоногоор үргэлжилсэн үед улсын нөөцөөс шаардлагатай бараа, материалын хангалт, тусламж үзүүлэх, нөөц бүрдүүлэхийг;

4.2.Олон улсын болон дотоодын хүмүүнлэгийн тусламжийг хүлээн авах, хуваарилах арга хэмжээ зохион байгуулахыг;

Тав. Гамшгаас хамгаалах сургалтын газрын дарга,
хурандаа Х.Сүхбаатарт

5.1.Гамшгаас хамгаалах, мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүн болон иргэдэд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймэр унтраах, аюулгүй байдлыг хангах чиглэлээр зохион байгуулж буй сургалт, дадлагад хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг;

5.2.Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар, бүлгийн алба хаагчдад Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагааны зааварчилгааг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэмд заагдсаны дагуу өгч, хамгаалах тусгай хувцсыг бүрэн өмсүүлж хэвшүүлэхийг;

5.3.Ой, хээрийн гал түймэр унтраах дадлага сургалтыг бие бүрэлдэхүүнд зохион байгуулахыг;

Зургаа. Эрсдэлийн удирдлагын газрын дарга,
хурандаа Д.Баасансүрэнд

6.1.Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн баталсан "Гамшгийн эрсдэлийн ерөнхий үнэлгээ хийх нэгдсэн удирдамж"-д зааснаар ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээг хийж, холбогдох бүтцийн нэгжүүдийг мэдээ, мэдээллээр ханган, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зөвлөмж гаргахыг;

6.2.Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээнд үндэслэн ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэг, мэдээ мэдээлэл, мэргэжлийн зөвлөгөөг бүх төрлийн мэдээллийн сувгаар олон нийтэд хүргэж, олон нийтэд чиглэсэн нөлөөллийн аян зохион байгуулахыг;

6.3.Гамшгийн орон зай мэдээллийн системд ой, хээрийн гал түймрийн мэдээллийн сан үүсгэж, бүртгэл хөтлөх, ой, хээрийн гал түймрийн үед ашиглах бүсчилсэн болон даргын ажлын зургийг шуурхай бэлтгэхийг;

6.4.Хиймэл дагуулын мэдээллийг ашиглан ой, хээрийн гал түймрийн голомтыг илрүүлж, тархалт, түймэрт өртсөн талбайн зураглал үйлдэж, удирдлагыг мэдээ, мэдээллээр хангахыг;

Долоо. Санхүү, ар талын газрын дарга,
хурандаа Т.Мөнхдоржид

7.1.“Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас” Ерөнхий шаардлага CS 11-0440:2020 “Гал түймрээс хамгаалах хүн нэг бүрийн хэрэгсэл” Ерөнхий шаардлага CS 11-0441:2020 стандартад нийцсэн ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр алба хаагч нэг бүрийг хангахад анхаарч, судалгаа хийх, худалдан авалтыг нэмэгдүүлэхийг;

7.2.Ой, хээрийн гал түймрийн голомтод олон хоног, удаан хугацаагаар ажилласан үед алба хаагчдын өдөр тутмын болон хамгаалах тусгай хувцасны эдэлгээний хугацааг харгалзахгүй нөхөн хангалт хийхийг;

7.3.Ой, хээрийн гал түймэр унтраах багаж хэрэгсэл болон туулах чадвар сайтай шуурхай албаны автомашины нөхөн хангалтыг нэмэгдүүлэхийг;

7.4.Зэвсэгт хүчний болон Агаараас эрэн хайх, аврах ангийн нисдэг тэргээр тусгай үүргийн нислэг үйлдсэн тохиолдолд нислэгийн төлбөрийг гэрээнд заасан хугацаанд хийхийг;

7.5.Ой, хээрийн гал түймэрт ажилласан алба хаагчдад гамшиг ослын томилолт олгохыг;

7.6.Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх албан хаагчдад өөрийгөө болон бусдыг зэрлэг ан амьтнаас хамгаалах зориулалттай дуу, гэрэл гаргах хэрэгслийг судлан, хангалтаар олгохыг;

Найм. Холбоо, мэдээллийн технологийн газрын дарга,
хошууч М.Отгонпүрэвт

8.1.Гамшгийн үеийн холбоо зохион байгуулалт, түймрийн голомтод ашиглах холбооны тоног төхөөрөмжийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж хэвийн, найдвартай ажиллагааг хангуулахыг;

8.2.Ой, хээрийн гал түймэр илрүүлэх, хянах, унтраах ажиллагаанд орчин үеийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэхийг;

8.3.Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй, орон нутгаас алслагдсан, үүрэн телефон, радио станцын сүлжээгүй газар гарсан ой, хээрийн гал түймрийн голомтоос Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар, бүлгүүдийн холбоонд орох нөхцөлийг бүрдүүлэх, сансрын холбооны утас, сансрын хөдөлгөөнт интернэтийн төхөөрөмжөөр хангахыг;

Ес. Үндэсний аврах бригадын захирагч,
бригадын генерал Ж.Чүлтэмсүрэнд

9.1.Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах бүрэлдэхүүнийг томилгоожуулан, албан хаагчдын болон автомашин техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн бэлтгэл бэлэн байдал, аюулгүй найдвартай ажиллагааг хангуулахыг;

9.2.Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, шүхрийн зааварлагч, шүхэрчин гал сөнөөгчдийн шүхрийн буултын дадлагыг зохион байгуулахыг;

9.3.Томилгоот бүрэлдэхүүнийг нисгэгчгүй нисэх төхөөрөмж, байршил тодорхойлогч /GPS/, салхины чиг, хурд хэмжигч, сансрын холбооны утас /IRIDIUM/, богино болон хэт богино долгионы гар, суурин холбооны хэрэгсэл сансрын хөдөлгөөнт интернэт төхөөрөмж (starlink), байр зүйн зургийн бэлэн байдлыг хангахыг;

9.4.Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөн, агаарын хөлгөөр зорчих, ачаа бараа тээвэрлэх үеийн аюулгүй байдлыг хангах сургалт, дадлага зохион байгуулж, ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд оролцох томилгоот бүрэлдэхүүний хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулж, холбогдох дүрэм, журмын дагуу зааварчилгаа өгөхийг;

Арав. 111 дүгээр ангийн захирагч,
хурандаа Б.Алтанбадралтад

10.1.Нисдэг тэрэгний техникийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж, хүн хүч, техник хэрэгслийг ой, хээрийн гал түймрийн голомтод шуурхай хүргэхийг;

10.2.Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий, алслагдсан аймаг, сумдад нисдэг тэрэг цэнэглэх шатахууны нөөц бүрдүүлэх, хүргэх ажлыг зохион байгуулж, бэлэн байдлыг хангахыг;

10.3.Ой, хээрийн бүсэд буулт хийх, хөөрөх үеийн аюулгүй ажиллагаа, хөдөлмөрийн аюулгүй байдлыг бүрэн хангуулж, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль бусад холбогдон гарсан дүрэм, журмыг судлуулан, зааварчилгаа өгөхийг;

10.4.Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хангах, газар орны нөхцөл байдлыг үнэлэх, нисгэгчдийн ур чадварыг дээшлүүлэх сургалт, дадлага зохион байгуулахыг.

Арван нэг. 113 дугаар ангийн захирагч,
хурандаа Д.Жаргалмөнхөд

11.1.Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөн аюулгүй байдлыг хангах, гал түймэрт нэрвэгдэгчдэд үзүүлэх анхны болон эмнэлгийн тусламж үзүүлэх сургалт, дадлага зохион байгуулахыг;

11.2.Шаардлагатай тохиолдолд ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа алба хаагчдад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх зорилгоор эмнэлгийн тусгай хэрэгсэлтэй эмч томилон ажиллуулах томилгоо хийх, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчилгаа өгч баталгаажуулахыг;

11.3.Ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд олон хоногоор үүрэг гүйцэтгэсэн алба хаагчдыг Гамшгаас хамгаалах тухай хуулийн 50 дугаар зүйлийн 50.4-т заасан сэтгэл зүйн болон бие бялдрын нөхөн сэргээх, сувилах үйлчилгээнд хамруулахыг;

Арван хоёр. 115 дугаар ангийн захирагч,
хурандаа Д.Гантулгад

12.1.Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх автомашин техник, тоног төхөөрөмжийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, засвар үйлчилгээг тогтмол хийж, шаардлагатай сэлбэг, хэрэгсэл, шатах, тослох материалын нөөц бүрдүүлэхийг;

12.2.Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах алба хаагч нэг бүрийг ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд зориулсан хамгаалах тусгай хувцас, хүн нэг бүрийн хамгаалах хэрэгслээр хангах, хувцас хэрэгслийн эдэлгээ, элэгдлийг тооцож, тухай бүр нөхөн хангалт хийхийг;

12.3.Бие бүрэлдэхүүнд ой, хээрийн гал түймэр унтраах, хөдөлмөрийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах сургалт, дадлага зохион байгуулахыг;

12.4.Салбар, нэгжийн Хүн тээврийн зориулалтаар ашиглагдаж буй ЗИЛ-131 автомашиныг ой, хээрийн гал түймрийн голомтод ажиллахад тохируулан тоноглож, бэлтгэл бэлэн байдал хангахыг;

Арван гурав. 119 дүгээр ангийн захирагч,
хурандаа Л.Тамирт

13.1.Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг холбогдох албан тушаалтанд шуурхай дамжуулахыг;

13.2.Ой, хээрийн гал түймрийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа бүлэг, бүсийн шуурхай удирдлагын төвтэй тогтмол холбоонд орж, удирдлагыг үнэн зөв бодитой мэдээ, мэдээллээр шуурхай хангахыг;

13.3.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн А/160 дугаар тушаалаар батлагдсан “Монгол Улсын хил орчмын нутаг дэвсгэрт гарсан ой, хээрийн гал түймрийн мэдээллийг Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын холбогдох байгууллагад дамжуулах заавар” – дагуу хөрш орнуудтай мэдээлэл солилцож, удирдлагыг мэдээллээр шуурхай хангахыг;

Арван дөрөв. Бүсийн төвийн
захирагч нарт

14.1.Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 06 дугаар сарын 02-ны өдөр баталсан “Онцгой байдлын байгууллагын бүсийн ажиллах журам”, Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А/190 дүгээр тушаалаар баталсан “Онцгой байдлын ерөнхий газрын ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын заавар”, мөн 2025 оны 06 дугаар сарын 06-ны өдөр баталсан “Ой, хээрийн гал түймрийн үеийн хүч, хэрэгслийг шуурхай зохион байгуулах төлөвлөлт” болон бүсийн төвийн үйл ажиллагааг зохицуулсан бусад холбогдох эрх зүйн баримт бичгийг мөрдлөг болгон ажиллахыг;

14.2.Ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажлыг бүсийн хэмжээнд эрсдэлийн зэрэглэлд тулгуурлан төлөвлөж, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллахыг;

14.3.Ой, хээрийн гал түймэртэй тэмцэх албаны бэлтгэл, бэлэн байдлыг хангуулах, ой, хээрийн гал түймэр унтраах ажиллагаанд бүсийн харьяа Онцгой байдлын газруудыг нэгдсэн удирдлагаар хангаж, унтраах ажиллагааг шуурхай зохион байгуулахыг;

14.4.Ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал хүндэрсэн үед нэмэлтээр ажиллах хүн хүч, техник, хэрэгсэл болон бусад шаардлагатай хангалтыг бүсийн хэмжээнд шуурхай зохион байгуулж ажиллахыг;

14.5.Ой, хээрийн гал түймэр унтраах дадлага, сургалтыг бүсийн хэмжээнд бүс нутгийн онцлогт тохируулан 1 дүгээр улиралд багтаан зохион байгуулахыг;

Арван тав. Төв, орон нутгийн

Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт

15.1.Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1, 17.1.5, 17.2.2, 17.2.7, 18 дугаар зүйлийн 18.1.1, 18.1.8, 18.2.2, 18.2.10, Галын аюулгүй байдлыг тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4, 15.1.7-д заасныг хэрэгжүүлэн ой, хээрийн гал түймрээс хамгаалах арга хэмжээний хөтөлбөр, төлөвлөгөө, шаардагдах төсвийг бүх шатны иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг хангах, тайлагнахыг;

15.2.Монгол Улсын Шадар сайдын 2021 оны 7 дугаар сарын 21-ний өдрийн 68 тоот тушаалын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн үнэлгээ хийх заавар”-ын дагуу орон нутгийн ой, хээрийн гал түймрийн эрсдэлийн ерөнхий үнэлгээг нутгийн захиргааны байгууллага, төрийн болон төрийн бус байгууллага, хуулийн этгээдийн оролцоотой хийхийг;

15.3.Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.14, 17.2.15, 17.2.20, 18 дугаар зүйлийн 18.2.4, 18.2.5, 18.2.11, 18.2.17, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.3-д заасны дагуу болон эрсдэлийн үнэлгээтэй уялдуулан аймаг, нийслэл, сум, дүүргийн хэмжээнд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, тэмцэх, сургалт, дадлага, иргэд олон нийт рүү чиглэсэн нөлөөллийн аян зохион байгуулж, хэрэгжилтийг ханган, үр дүнг тооцохыг;

15.4.Ой, хээрийн гал түймрийн эрсдэл өндөртэй бүс нутагт, Ойн тухай хуулийн 3.1.17-д заасан хугацаанд ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, түймэр унтраах зорилгоор шуурхай хөдөлгөөнт бүлэг ажиллуулах, нөхцөл байдал хүндэрсэн үед бусад бүсээс алба хаагчдыг татан ажиллуулахыг.

15.5.Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан “Гамшгаас хамгаалах сайн дурын ажиллагааны нийтлэг журам”, “Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам”-д заасны дагуу сайн дурын хэсгийн дарга, жолооч, гал сөнөөгчийн мэргэшүүлэх, дадлагажуулах сургалт зохион байгуулахыг;

15.6.Төв, орон нутгийн телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, цахим орчныг ашиглан хавар, намрын хуурайшилтын болон зуны хэт халалтын үед иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх чиглэлээр сэрэмжлүүлэг, мэдээ, мэдээлэл түгээхийг;

15.7.Хил орчмын ой, хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх ажиллагаанд хөрш орны Онцгой байдлын газартай хамтран ажиллах санамж бичиг, төлөвлөгөө батлуулж, хамтарсан дадлага сургалтыг зохион байгуулахыг;

15.8.Ой, хээрийн гал түймрийн эрсдэл бүхий бүс нутагт үйл ажиллагаа эрхэлдэг айл өрх, амралтын газар, жуулчны бааз, мод, хадлан бэлтгэх бүлэг нөхөрлөл зэрэг иргэн, хуулийн этгээдийн барилга байгууламжид Онцгой байдлын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу гал түймрийн улсын хяналт шалгалтыг мэргэжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, илэрсэн

зөрчлийг арилгуулах, ой, хээрийн гал түймэр унтраах анхан шатны багаж хэрэгслийн нөөц бүрдүүлэх, бэлэн байдлыг хангуулахыг;

15.9.Ой, хээрийн гал түймрийн аюултай үе буюу жил бүрийн 03 дугаар сарын 20-ны өдрөөс 06 дугаар сарын 10-ны өдөр, 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд болон зуны хэт халалтын үед Ойн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.18, 18 дугаар зүйлийн 18.2.12, 18.2.14- д заасныг хэрэгжүүлэх, ой, хээрийн гал түймрийн эрсдэлтэй бүсэд үйлдвэрлэл, үйлчилгээ болон бусад үйл ажиллагаа явуулахыг хязгаарлах, зогсоох саналыг, орон нутгийн төрийн захиргааны байгууллагад танилцуулан шийдвэрлүүлж, хяналт, шалгалтын цэг, хөдөлгөөнт эргүүл томилон ажиллуулахыг;

15.10.Ой, хээрийн гал түймэр унтраах томилгоот бүрэлдэхүүн, орон нутгийн гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн анги, гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг, дайчлагдан ажиллах иргэдийн хувийн бэлтгэл, бэлэн байдлыг хангах, автомашин, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/191 дугаар тоот тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах автомашин, техникийн тусгай тоноглол, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг туршин шалгах, үйлчилгээ хийх заавар"-ын дагуу засвар үйлчилгээ хийж, аюулгүй, найдвартай ажиллагааг хангах, шаардлагатай сэлбэг, хэрэгслийн нөөцийг бүрдүүлэхийг;

15.11.Байнгын болон ой, хээрийн гал түймрийн голомтод ашиглах холбоо, мэдээллийн технологийн тоног төхөөрөмж, сүлжээний хэвийн ажиллагаа, холбооны чанар байдлыг шалгаж, бэлтгэл бэлэн байдлыг хангахыг;

15.12.Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2015 оны А/346 дугаар тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан "Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсэг ажиллуулах журам"-ын 10.2 дахь зүйлийг хэрэгжүүлэн орон нутагт байгуулагдсан Гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн гал унтраах зориулалтын автомашин, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, суурин болон хөдөлгөөнт холбооны хэрэгслүүдийг бүрдүүлэх, нэмэгдүүлэхээр нутгийн захиргааны байгууллагатай хамтарч ажиллахыг;

15.13.Бие бүрэлдэхүүнийг ой, хээрийн гал түймрийн дуудлагаар гарч ажиллах, буцах, түймрийн голомтод үүрэг гүйцэтгэх үед Монгол Улсын Шадар Сайдын 2024 оны 24 дүгээр тушаалаар батлагдсан "Гал түймэр унтраах дүрэм", Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2023 оны А/338 дугаар тушаалаар батлагдсан "Онцгой байдлын байгууллагын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм" болон Засгийн газрын 2018 оны 239 дүгээр тогтоолоор батлагдсан "Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, дүрэм"-ээр сургалт зохион байгуулж, холбогдох заалтуудыг чанд мөрдөж, хэвшүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихыг;

15.14.Ой, хээрийн гал түймрийн дуудлага ирсэн даруйд Онцгой байдлын газар, хэлтсийн Эрэн хайх аврах анги, Салбар, бүлгийн томилгоот ээлжийн бүрэлдэхүүнийг эхний дуудлагаар шуурхай гаргах, Эрэн хайх, аврах нэгжгүй орон нутагт Гал түймэр унтраах, аврах анги, орон нутгийн мэргэжлийн анги, сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг гаргах, нэмэлтээр гарах бүлгийг богино хугацаанд бэлэн байдлыг хангуулахыг;

15.15.Ой, хээрийн гал түймрийн дуудлагаар ажиллах бүрэлдэхүүнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрмийн зааварчилгаа өгч

баталгаажуулах, байршил тодорхойлогч (GPS), салхины чиг, хурд хэмжигч, сансрын холбооны утас (IRIDIUM), сансрын хөдөлгөөнт интернэт, богино болон хэт богино долгионы гар, суурин холбооны хэрэгсэл, байр зүйн зургаар хангаж шуурхай дуудлагаар ажиллуулахыг;

15.16.Ой, хээрийн гал түймрийн мэдээ, мэдээллийг хүлээн авсан албан тушаалтан цаг агаарын болон ой, хээрийн гал түймрийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаарх мэдээллийг Онцгой байдлын ерөнхий газрын Гал түймэртэй тэмцэх газрын ой, хээрийн гал түймрийн асуудал хариуцсан мэргэжилтэн нарт цаг алдалгүй шуурхай мэдээлэхийг;

15.17.Гамшгаас хамгаалах тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.2 дахь заалтыг хэрэгжүүлэн Орон нутгийн гамшгаас хамгаалах алба, хуулийн этгээд, мэргэжлийн ангийн удирдах албан тушаалтан, цэргийн албыг биеэр дүйцүүлэн алба хааж байгаа иргэний сургалтыг зохион байгуулахыг;

15.18.Ойн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.1-д заасныг хэрэгжүүлэн Засгийн газрын 2013 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Ой, хээрийн түймрээс учирсан хохирлыг тооцох журам”-ын дагуу экологийн болон эд хөрөнгөд учирсан хохирол, түймрийг унтраахад гарсан зардлыг хуулийн хугацаанд, үнэн зөв тооцоход хяналт тавихыг;

Албан даалгаврын биелэлтэд хяналт тавьж, мэдээ тайланг 06 дугаар сарын 08-ны өдөр, 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор Гал түймэртэй тэмцэх газарт ирүүлэхийг бүтцийн нэгж, бүсийн төв, төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН